



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 15.3, 16.1, 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 03/6.1-1 кодтой Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 1 дүгээр, 03/6.1-2 кодтой Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 2 дугаар, 03/6.1-3 кодтой Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 3 дугаар, 03/6.1-4 кодтой Дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 4 дүгээр, 03/6.1-5 кодтой Ерөнхий боловсролын сургуулийн сурагцагчдын дотуур байрны үйлчилгээг шалгах хяналтын хуудсыг 5 дугаар, 03/6.1-6 кодтой Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны үйлчилгээг шалгах хяналтын хуудсыг 6 дугаар, 03/6.1-7 кодтой Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 7 дугаар, цөмийн болон цацрагийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 03/8.1-1 кодтой Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, судалгааны цөмийн болон цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 8 дугаар, 03/8.1-2 кодтой Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын цөмийн болон цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 9 дүгээр, 03/8.2-1 кодтой Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 10 дугаар, 03/8.2-2 кодтой Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 11 дүгээр, 03/8.2-3 кодтой Рентген багаж, тоног төхөөрөмжийн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 12 дугаар, 03/8.2-4 кодтой Туяа эмчилгээний цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 13 дугаар, 03/8.2-5 кодтой Цөмийн онош зүйн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 14 дүгээр, 03/8.2-6 кодтой Цөмийн материал, цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэх тусгай байгууламжийн цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг 15 дугаар, 03/8.2-7 кодтой Цооногийн өрөмдлөгийн судалгаанд ашиглаж буй цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 16 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

12231 0288

2. Батлагдсан хяналтын хуудсыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга /Б.Батгэрэл/ нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

